



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.16 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1.14 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.7, 60.3, 60.5 дахь хэсэг Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.6 дахь хэсэг, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 192, А/243 дугаар хамтарсан тушаал, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2022 оны А/82 дугаар тушаалыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит II хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад дараах өөрчлөлтийг оруулсугай.

1.1. 2.2. “8 нэрийн хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 50 мк² хүртэл/ 100,000 төгрөг” гэснийг “8 нэрийн хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 50 мк² хүртэл/ 70,000 төгрөг” гэж;

1.2. 2.3. “8 нэрийн хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 51-200 мк² хүртэл болон Супермаркет/ 130,000 төгрөг” гэснийг “8 нэрийн хүнсний дэлгүүр /Талбайн хэмжээ 51-200 мк² хүртэл болон Супермаркет/ 90,000 төгрөг” гэж;

1.3. 2.6. “Хүнсний зах 150,000 төгрөг /нэг рейсийн үнэ/” гэснийг “Хүнсний зах 200,000 төгрөг /нэг рейсийн үнэ/” гэж;

1.4. 2.7. “Барааны зах 150,000 төгрөг /нэг рейсийн үнэ/” гэснийг “Барааны зах 200,000 төгрөг /нэг рейсийн үнэ/” гэж;

1.5. 2.8. “Их дэлгүүр 2,000,000 төгрөг” гэснийг “Их дэлгүүр 200,000 төгрөг /нэг рейсийн үнэ/” гэж;

2. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын

нэгдүгээр хавсралтын 6.3.“Банк, Банк бус санхүүгийн байгууллагууд салбар бүрээр” гэсний “Банк бус санхүүгийн байгууллагууд салбар бүрээр” гэснийг хассугай.

3.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 22 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад 6.3.1.“Банк бус санхүүгийн байгууллагууд салбар бүрээр 70,000 төгрөг” гэж нэмсүгэй.

4.Энэ тогтоолын нэмэлт, өөрчлөлтийг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, сурталчлан таниулж, дагаж мөрдүүлэхийг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д үүрэг болгосугай.

5.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР